



**ДЭЛХИЙ НИЙТЭЭР ХДХВ, ДОХ-ЫН АСУУДАЛД АНХААРАЛ ХАНДУУЛАХ
ДЭЛХИЙН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛЖ ЗОХИОН
БАЙГУУЛАХ "ДЭВЖЭЭ" ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

2023-11-22

ҮНДЭСЛЭЛ: "Дэлхий нийтээр ХДХВ, ДОХ-ын асуудалд анхаарал хандуулах өдөр"- ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай санаачилгыг 1988 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага гаргаж, жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийг дэлхийн улс орнууд ХДХВ./ДОХ-той тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, халдвараас сэргийлэх, хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх, нөлөөллийн ажлыг зохион байгуулж сурталчилан таниулах үйл ажиллагааг зохион байгуулсаар ирсэн. Монгол Улсад 1992 оноос 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ХДХВ/ДОХ-ын тохиолдол өссөн дүнгээр 367, нас баралт 63 бүртгэгдсэн байна.

ЗОРИЛГО: Эрдэнэдалай сумын өсвөр үеийн хүүхэд залуучуудад Хүний дархлал хомсдолын вирус, Дархлалын олдмол хомсдолтой тэмцэх дэлхийн өдөр буюу "ДОХ- той тэмцэх Дэлхийн өдөр"ийг сурталчилан таниулах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг хандлага, дадал хэвшилд сургахад энэхүү тэмцээний зорилго оршино.

ХҮРЭХ ҮР ДҮН: Өсвөр үеийн хүүхэд залуучуудад Хүний дархлал хомсдлын вирус, дархлалын олдмол хомсдлын халдвараас өөрийгөө болон бусдыг хамгаалах, эрүүл мэндийн боловсролын түвшин нэмэгдэж эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдлэг, чадвар, хандлагатай болсон байна.

ХАМРАХ ХҮРЭЭ:

- ЕБС-ийн 10-12 дугаар ангийн сурагчид
- Анги удирдаагүй бага, дунд ахлах ангийн багш нар

ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ТЭМЦЭЭНИЙ ТӨРӨЛ:

1. МЭНДЧИЛГЭЭ

Мэндчилгээ нь ХДХВ, ДОХ-ын асуудалд анхаарал хандуулах Дэлхийн өдрийн хүрээнд "Та халдвартай эсэхээ мэдэх үү", "ХДХВ, ДОХ-ТОЙ хэрхэн

тэмцэх вэ?", "Яг одоо шинжилгээнд" гэсэн 3 сэдвийн хүрээнд аль 1-г сонгох /Хугацаа 3-5 минут багийн үндсэн гишүүд оролцоно/.

2. ГЭРИЙН ДААЛГАВАР:

- ХДХВ, ДОХ-ын асуудалд анхаарал хандуулах Дэлхийн өдрийн хүрээнд "ХДХВ, ДОХ-ТОЙ хэрхэн тэмцэх вэ" уриан дор ханын самбар байршуулах.
- "ХДХВ, ДОХ-ТОЙ хэрхэн тэмцэх вэ?" жүжигчилсэн тоглолт /Жүжигчилсэн тоглолтын хугацаа 8-10 минут/

3. БАГИЙН АХЛАГЧИЙН ТЭМЦЭЭН: Багийн ахлагч бэлдсэн асуултнаас сугалж хариулах /Бодох хугацаа 3 минут/

4. ЧӨЛӨӨТ СЭТГЭЛГЭЭ: Багийн үндсэн гишүүд оролцоно /Хугацаа 3-5 минут/

ТЭМЦЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

1. Тэмцээн 10 хүний бүрэлдэхүүнтэй оролцоно.
2. Багийн нэр, уриалга, логотой байх
3. Хугацаа 20-25 минутад багтах
4. Тэмцээнд шаардлагатай аяыг өөрсдөө бэлтгэж авчрах

ХААНА, ХЭЗЭЭ БОЛОХ: Эрдэнэдалай сумын Б сургуулийн Спорт заланд
2023.12.01 14:00 цагт

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

- 1-р байр Өргөмжлөл, үнэ бүхий зүйл
- 2-р байр Өргөмжлөл, үнэ бүхий зүйл
- 3-р байр Өргөмжлөл, үнэ бүхий зүйл
- Тусгай байр Өргөмжлөл, үнэ бүхий зүйл

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН
УХААНЫ ЗААХ АРГЫН НЭГДЭЛ

ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

**БОЛОВСРОЛЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛТТЭЙ ХОЛБОГДУУЛАН БАГШ
НАРЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ “ЦЭНЭГЛЭХ ЦАГ” ТЭМЦЭЭНИЙ
УДИРДАМЖ**

2023-11-20

Сангийн далай

ЗОРИЛГО: Монгол Улсад Боловсролын хуулийн шинэчлэлт хийгдсэнтэй холбогдуулан хуулиа сурталчлах, багш нарын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, танин мэдэхэд оршино.

Хамрах хүрээ:

Гадаад хэлний ЗАН
Монгол хэлний ЗАН
Математикийн ЗАН
Бага ангийн ЗАН
Гоо зүйн ЗАН
Байгалийн Ухааны ЗАН

Тэмцээний журам:

1. Дээрх Заах аргын нэгдлүүд дангаараа болон хамтран танин мэдэхүйн тэмцээнд оролцоно.
2. Багууд багтаа нэр өгсөн байх
3. Багийн аль нэг гишүүний ухаалаг утсанд **КАНООТ** аппликейшнийг татаж суулгасан байх
4. Тэмцээний туршид хэрэглэгдэх өндөр хурдны хангалттай дататай байх
5. Тэмцээн нь нь хариултын ширээнд суусан баг бүр “Боловсролын ерөнхий хууль”, “Ерөнхий боловсролын хууль”-ийн агуулгаар бэлтгэгдсэн **КАНООТ** программын асуултанд өгөгдсөн минутад багтаан зөв хариултыг илгээсэн тохиолдолд цахимаар оноо цуглуулах зарчмаар явагдана.
6. Хамгийн өндөр оноо цуглуулсан 3 багийг шалгаруулж өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнана.

Хугацаа: Танин мэдэхүйн тэмцээн 2023 оны 11-20-ны өдрийн 17:30 цагт сургуулийн урлаг заланд болно.

Зохион байгуулагч

Сургуулийн захиргаа

ТНУ-ы Заах аргын нэгдлийн хамт олон